FISCAL
AUDITING, ADVISORY, ASSURANCE

**"ФИСКАЛ АУДИТ" ХХК**
Монгол улс,Улаанбаатар-14241
Сүхбаатар дүүрэг 7-р хороо,11-р хороолол, Эрхүүгийн гудамж , Ориент төв 208 тоот
Утас/факс: (976)- 70106099, 99192177, 99991914
E-mail: audit@fiscal.mn , altantugs@fiscal.mn

2023.08.15 № СТА 43/23

танай ____________-ны № ______________-т

**"ТАВИЛГА" ХК-ИЙН УДИРДЛАГАД**

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

**"ТАВИЛГА" ХК**-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд **"ТАВИЛГА" ХК**-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

## Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

## Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

## Санхүүгийн тайлангийн талаархи компаний удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материалаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

бүртгэлийн зохих бодлогыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

**Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилсан сонгодог бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компаний санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдалд байгаа эсэхийг тодорхойлсон.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Компаний тухай хууль"-ийн 5-р зүйлд заасан хуулийн этгээд болох **"ТАВИЛГА" ХК**-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

"ФИСКАЛ АУДИТ" ХХК
FISCAL AUDIT
УЛААНБААТАР ХОТ

ЗАХИРАЛ Д.АЛТАНТӨГС

FISCAL
AUDITING, ADVISORY, ASSURANCE

**“Тавилга” ХК**
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
**Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан**
(мян.төг)

| | 2021/12/31 | 2022/12/31 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 28,680,360.79 | 28,805,477.50 |
| Дансны авлага | | 14,020,127.00 |
| Татвар, НДШ-ийн авлага | 3,394,546.31 | 3,394,546.31 |
| Бусад авлага | 900.00 | 900.00 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| Бараа материал | | |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | |
| Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | | |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **32,075,807.10** | **46,221,050.81** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 252,614,002.34 | 252,614,002.34 |
| Биет бус хөрөнгө | 156,217,257.00 | 156,217,257.00 |
| Биологийн хөрөнгө | | |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | | |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | | |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх | | |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **408,831,259.34** | **408,831,259.34** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **440,907,066.44** | **455,052,310.15** |

ЗАХИРАЛ Д.АЛТАНТӨГС

АУДИТОР Н.БОЛОРЦЭЦЭГ

FISCAL
AUDITING, ADVISORY, ASSURANCE

**"Тавилга" ХК**
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
**Санхүүгийн байдлын тайлан**
(мян.төг)

| | 2021/12/31 | 2022/12/31 |
|---|---|---|
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | | 56,647,344.00 |
| Цалингийн өглөг | | 0.17 |
| Татварын өглөг | 15,684,303.93 | 28,763,526.82 |
| НДШ-ийн өр | 2,289,020.18 | 4,170,958.91 |
| Банкны богино хугацаат зээлийн өглөг | | |
| Хүүний өглөг | | |
| Ногдол ашгийн өглөг | | |
| Урьдчилж орсон орлого | | 30,755,200.00 |
| Нөөц /өр төлбөр/ | | |
| Бусад богино хугацаат өр төлбөр | | |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр | | |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **17,973,324.11** | **120,337,029.90** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | |
| Урт хугацаат зээл | | |
| Нөөц /өр төлбөр/ | | |
| Хойшлогдсон татварын өр | | |
| Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **17,973,324.11** | **120,337,029.90** |
| **Эзэмшигчийн өмч** | | |
| Эзний өмч /хувийн/ | 472,147,921.89 | 472,147,921.89 |
| Халаасны хувьцаа | | |
| Нэмж төлөгдсөн капитал | | |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | | |
| Хуримтлагдсан ашиг / алдагдал / | (49,214,179.56) | (137,432,641.64) |
| **Эзэмшигчийн өмчийн нийт дүн** | **422,933,742.33** | **334,715,280.25** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **440,907,066.44** | **455,052,310.15** |

"ФИСКАЛ АУДИТ" ХХК
FISCAL AUDIT LLC

ЗАХИРАЛ Д.АЛТАНТӨГС

АУДИТОР Н.БОЛОРЦЭЦЭГ

FISCAL
AUDITING, ADVISORY, ASSURANCE

**"Тавилга" ХК**
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
**Дэлгэрэнгүй орлогын тайлан**
(мян.төг)

| | 2021/12/31 | 2022/12/31 |
|---|---|---|
| Борлуулалтын орлого (цэвэр) | | 172,488,349.01 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | |
| **Нийт ашиг/алдагдал** | **-** | **172,488,349.01** |
| Түрээсийн орлого | 23,405,957.27 | |
| Хүүний орлого | | |
| Ногдол ашгийн орлого | | |
| Эрхийн шимтгэлийн орлого | | |
| Бусад орлого | | |
| Борлуулалт,маркетингийн зардал | | |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 94,258,917.23 | 260,601,811.09 |
| Санхүүгийн зардал | | |
| Бусад зардал | | 105,000.00 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| Бусад ашиг (алдагдал) | | |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(70,852,959.96)** | **(88,218,462.08)** |
| Орлогын татварын зардал | | |
| **Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | **(70,852,959.96)** | **(88,218,462.08)** |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **(70,852,959.96)** | **(88,218,462.08)** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | **-** | **-** |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| Бусад олз (гарз) | - | - |
| **Нийт дэлгэрэнгүй орлогын дүн** | **(70,852,959.96)** | **(88,218,462.08)** |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

"ФИСКАЛ АУДИТ" ХХК
FISCAL AUDIT LLC

ЗАХИРАЛ Д.АЛТАНТӨГС

АУДИТОР Н.БОЛОРЦЭЦЭГ

FISCAL
AUDITING, ADVISORY, ASSURANCE

**“Тавилга” ХК**
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
**Өмчийн өөрчлөлтийн тайлан**
(мян.төг)

| Агуулга | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Дахин үнэлгээний нэмэгдэл | Халаасны хувьцаа | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг/алдагдал | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **472,147,921.89** | - | - | - | - | (49,214,179.56) | **422,933,742.33** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | - | - | | - |
| Залруулсан үлдэгдэл | **472,147,921.89** | - | | - | - | (49,214,179.56) | **422,933,742.33** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | - | - | - | - | (88,218,462.08) | (88,218,462.08) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | - | | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | | - | - | - | - | | |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | - | | - |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | - | - | | - |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **472,147,921.89** | - | - | - | - | **(137,432,641.64)** | **334,715,280.25** |

ЗАХИРАЛ ——— Д.АЛТАНТӨГС

АУДИТОР ——— Н.БОЛОРЦЭЦЭГ

AUDITING, ADVISORY, ASSURANCE

**“Тавилга” ХК**
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
**Мөнгөн гүйлгээний тайлан**

(мян.төг)

| | **2021/12/31** | **2022/12/31** |
|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (47,463,330.90) | (56,388,623.29) |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний дүн | | |
| Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | 56,513,740.00 |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(47,463,330.90)** | **125,116.71** |
| Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 76,143,691.69 | 28,680,360.79 |
| Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 28,680,360.79 | 28,805,477.50 |

"ФИСКАЛ АУДИТ" ХХК
FISCAL AUDIT LLC
5284597 - СБТ0676
УЛААНБААТАР ХОТ

ЗАХИРАЛ Д.АЛТАНТӨГС

АУДИТОР Н.БОЛОРЦЭЦЭГ

"ТАВИЛГА" ХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2022 оны 12-р сарын 31.

## 1. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮНДСЭН ЗАРЧИМ

"Тавилга" ХК-ийн санхүүгийн тайлангууд нь МУ-ын СЭЗЯамнаас гаргасан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, дансны үлгэрчилсэн заавар" санхүүгийн тайланг бэлтгэх аргачлалын дагуу аккурэл суурьиар бэлтгэгдсэн. Энэхүү тайлагналын суурь нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарттай нийцэж байна.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

### а. Тайлагнасан валют

Компаний данс бүртгэл нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хөтлөгддөг ба санхүүгийн тайланг төгрөгөөр бэлтгэсэн болно.

### б. Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хэрэгслүүд

Мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, арилжааны банк дахь харилцах дансдаас бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах гурван сар ба түүнээс бага хугацаанд хөрвөх богино хугацаат хөрөнгө оруулалт, түргэн борлогдох үнэт цаас байхгүй.

### в. Авлага

Авлага нь үүссэн тухайн үеийн нэхэмжлэгдэх дүнгээр бүртгэгдсэн. Авлагын хувьд насжилт гаргаж, цуглуулагдах магадлалыг үнэлж тооцдоггүй. Өөрөөр хэлбэл цэвэр боломжит үнэ цэнийг тооцдоггүй.

### г. Бараа материал

Бараа материалыг өртгөөр нь бүртгэдэг. Бараа материалын бүрэлдэхүүнд борлуулах бараа бүтээгдэхүүн, хангамж үйлчилгээний зориулалтын ашиглах материал үнэт зүйлс багтдаг.

### д. Урьдчилж гарсан зардал

Мөнгөөр төлөгдсөн бөгөөд дараагийн тайлант үед хамаарах зардлыг урьдчилж гарсан зардал дансанд бүртгэдэг. Урьдчилж гарсан зардлыг хамрах тайлант үеийн холбогдох зардлын дансанд хаадаг.

### е. Үндсэн хөрөнгө ба элэгдэл

Үндсэн хөрөнгө нь санхүүгийн тайланд анхны өртөг болон шинээр нэмж оруулсан хөрөнгө оруулалтыг капиталжуулан нэмэгдүүлсэн дүнгээс хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр илэрхийлсэн.

Хөрөнгийг данснаас хасах үед анхны болон шинэчлэн тогтоосон өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хасаж, үлдэх өртөг ба борлуулсан үнийн зөрүүгээр данснаас хассаны ашиг алдагдлыг тооцдог.

Элэгдлийг хөрөнгийн ашиглагдах жилийг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулдаг. Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа нь Монгол улсын "Аж ахуйн нэгжийн орлогын албан

татварын тухай" хуультай нийцдэг. Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа нь дараах хэмжээтэй байна.

| **Үндсэн хөрөнгийн төрөл** | **Ашиглах жил** |
|---|---|
| Барилга байгууламж | 25 |
| Тоног төхөөрөмж | 10 |
| Тээврийн хэрэгсэл | 10 |
| тавилга эд хогшил | 10 |
| Компьютер | 2 |

**з. Богино хугацаат өр төлбөр**

Богино хугацаат өр төлбөрийг тухайн үед үүссэн нэхэмжлэгдэх буюу нэрлэсэн дүнгээр бүртгэлд тусгадаг. Өглөгийн хувьд хөнгөлөлт, хасагдуулга нөөц тооцдоггүй.

**ж. Өмч**

Компанийн өөрийн хөрөнгө ( Дүрмийн сан) нь энгийн хувьцаа, халаасны хувьцаа, нэмж төлөгдсөн капитал, хөрөнгийн дахин үнэлгээний нөөц зэргээс бүрддэг бөгөөд давуу эрхтэй хувьцаа зэрэг бусад данс байхгүй

**и. Орлогыг хүлээн зөвшөөрөлт**

Бараа үйлчилгээг үзүүлж, өмчлөх эрх нь шилжсэн үед борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Ногдол ашгийн орлогыг шилжиж ирсэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

**к. Зарлагын хүлээн зөвшөөрөлт**

Зардлыг орлогын хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан нэг цаг хугацаанд тооцож байна. Зардлыг аккруэл сууриар бүртгэдэг.

**л. Гадаад валютын ажил гүйлгээ, хөрвүүлэлт**

Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн зүйлсийг балансын дуусвар болсон өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэсэн.

**м. Татвар**

<u>Орлогын татвар</u>

Татварын хуулийн дагуу 3.0 тэрбум төгрөг хүртэлх татвар ноогдох жилийн орлогод 10 хувиар, 3.0 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого олсон бол 300.0 сая төгрөг дээр 3.0 тэрбумаас дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ногдуулж төлдөг.

<u>Нэмэгдсэн өртгийн албан татвар</u>

Компани нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бөгөөд борлуулалтад 10 хувиар тооцож, нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг. Нэмэгдсэн өртгийн албан татвартай худалдан авсан бараа, ажил үйлчилгээнд төлсөн татварыг борлуулалтаас тооцсон татварын өглөгөөс суутган тооцдог.

Хувь хүний орлогын албан татвар

Монгол улсын "Хувь хүний орлогын албан татварын тухай" хуулийн дагуу компани ажиллагсад болон гэрээт ажилчидад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоос 10 хувиар татвар суутгаж төсөвт төлөх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол улсын Нийгмийн болон Эрүүл мэндийн даатгалын туай хуулийн дагуу ажиллагсдын сарын нийт цалингаас 11,5 хувиар тооцож ажиллагсад, 12,5 хувиар тооцож ажил олгогч нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг. Энэ нь Засгийн газрын нийгмийн даатгалын төлөвлөгөө бөгөөд компани ажиллагсаддаа зориулсан тусгай нийгмийн даатгалын төлөвлөгөө, сангүй болно.

## 1.МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

| | Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Касс дахь бэлэн мөнгө | 27,965,868.32 | 16,828,119.21 |
| 2. | Харилцах дахь бэлэн мөнгө /доллар/ | 714,492.47 | 11,977,358.29 |
| | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн:** | **28,680,360.79** | **28,805,477.50** |

## 2.АВЛАГА

| | Ангилал | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Дансны авлага | | 14,020,127.00 |
| 2. | Бусад авлага | | 900,00 |
| | **Дэд дүн** | - | **14,021,027.00** |
| | | | |
| 1. | ААНОАТ-ын авлага | 2,378,633.57 | 2,378,633.57 |
| 2. | НӨАТ-ын авлага | | |
| 3. | ХХАОТ-ын авлага | | |
| 4. | НДШ-ийн авлага | | |
| | **Дэд дүн** | 2,378,633.57 | 2,378,633.57 |
| | **Нийт авлагын дүн:** | **2,378,633.57** | **16,399,760.57** |

## 3.УРЬДЧИЛЖ ГАРСАН ЗАРДАЛ/ТООЦОО

| | Урьдчилж гарсан тооцоо | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| 3. | Урьдчилж гарсан зардал/тооцоо | - | - |
| 4. | | | |
| | **Урьдчилж гарсан зардал/тооцоо дүн:** | | **0** |

## 3. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгө нь газар, барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, холбоо хөгжим тоног төхөөрөмж зэргээс бүрддэг. Үндсэн хөрөнгийг дараах гол ангиллаар харуулав.

А. Өртөг

| Утга | Газар | Барилга байгууламж | Тоног төхөөрөмж | Тээврийн хэрэгсэл | Тавилга, эд хогшил | Компьютер, бусад хэрэгсэл | Бусад үндсэн хөрөнгө | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2021.12.31** | | **475,000,000** | **18,963,468.49** | **14,300,000** | **16,777,865.18** | **2,885,500** | **156,217,257** | **684,144,090.67** |
| **Нэмэгдсэн** | | | | | | | | |
| **Хасагдсан** | | | | | | | | |
| **2022.12.31** | | **475,000,000** | **18,963,468.49** | **14,300,000** | **16,777,865.18** | **2,885,500** | **156,217,257** | **684,144,090.67** |

Б. Хуримтлагдсан элэгдэл

| Утга | Газар | Барилга байгууламж | Тоног төхөөрөмж | Тээврийн хэрэгсэл | Тавилга, эд хогшил | Компьютер, бусад хэрэгсэл | Бусад үндсэн хөрөнгө | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2021.12.31** | | **235,290,077.99** | **11,463,468.49** | **9,771,666.67** | **16,588,357.76** | **2,199,260.42** | | **275,312,831.33** |
| **Нэмэгдсэн** | | | | | | | | |
| **Хасагдсан** | | | | | | | | |
| **2022.12.31** | | **235,290,077.99** | **11,463,468.49** | **9,771,666.67** | **16,588,357.76** | **2,199,260.42** | | **275,312,831.33** |

## 4. ӨГЛӨГ

| | Ангилал | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| | **А. Дансны өглөг** | | |
| 1. | Дансны өглөг | | 56,647,344.00 |
| | **Дэд дүн:** | | **56,647,344.00** |
| | | | |
| 1. | ААНОАТ-ын өглөг | | |
| 2. | НӨАТ-ын өглөг | 9,941,940.03 | 20,012,425.79 |
| 3. | ХХОАТ-ын өглөг | 957,741.50 | 3,966,478.63 |
| 4. | Бусад татварын өр | 7,073,642.58 | 39,710,781,48 |
| | **Дэд дүн:** | **17,973,324.11** | **63,689,685.90** |
| | **Нийт өглөгийн дүн:** | **17,973,324.11** | **120,337,029.90** |

## 5. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

| | Эздийн өмч | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Эздийн өмч | 472,147,921.89 | 472,147,921.89 |
| 2. | Халаасны хувьцаа | | |
| 3. | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 4. | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| 5. | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| 6. | Хуримтлагдсан ашиг | (49,214,179.56) | (137,432,641.64) |
| | **Нийт эздийн өмчийн дүн** | **422,933,742.33** | **334,715,280.25** |

## 6. БОРЛУУЛАЛТ

| | Борлуулалтын орлогын төрөл | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| | **А.Борлуулалтын орлого /цэвэр/** | | |
| 1. | Борлуулалтын орлого | | 172,488,349.00 |
| 2. | Борлуулалтын хөнгөлөлт, буцаалт | | |
| | **Дэд дүн:** | | **172,488,349.00** |
| | **Б.Бусад орлого** | | |
| 3. | Түрээсийн орлого | 23,405,957.27 | |
| 4. | Хүүгийн орлого | | |
| 5. | Хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого | | |
| 6. | Бусад орлого | | |
| | **Дэд дүн:** | | |
| | **Нийт борлуулалтын орлогын дүн** | **23,405,957.27** | **172,488,349.00** |

## 7. БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

| | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | |
| | **Дүн** | | **0** |

## 8. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

| | Зардлын ангилал | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Цалин хөлс, шагнал | | 44,717,391.30 |
| 2. | Нийгмийн даатгалын шимтгэл | | 5,577,193.91 |
| 3. | Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | | 9,816,377.34 |
| 4. | Томилолтын зардал | | |
| 5. | Бичиг хэргийн зардал | | 982,666.38 |
| 6. | Шуудан холбооны зардал | | 188,130.25 |
| 7. | Мэргэжлийн үйлчилгээний зардал | | 4,020,000.00 |
| 8. | Сургалтын зардал | | |
| 9. | Даатгалын зардал | | |
| 10. | Ашиглалтын зардал | | 11,938,099.06 |
| 11. | Засварын зардал | | 51,044,180.92 |
| 12. | Элэгдэл хорогдлын зардал | | |
| 13. | Түрээсийн зардал | | |
| 14. | Тээврийн зардал | | |
| 15. | Бусад зардал | 94,258,917.23 | 132,317,771.93 |
| | **Нийт зардал** | **94,258,917.23** | **260,601,811.09** |

## 9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО БА ЗАРДАЛ

| | Ангилал | 2021.12.31 | 2022.12.31 |
|---|---|---|---|
| 1. | Бусад ашиг (алдагдал) | | |
| 2. | Вальютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжсэн ашиг (алдагдал) | | |
| 3. | Вальютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй ашиг (алдагдал) | | |
| 4. | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| | **Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) -ын дүн** | **-** | **-** |